



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймаг Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/106/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020

Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

1.Төрийн аудитын санал, дүгнэлт


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

**ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Г.АЛТАНЦАЦРАЛ
ТАНАА**

Ауд. 02 25 № 1-6/258
танай _____ -ны № _____ -г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>85,563,605.76</u>	<u>140,490,727.76</u>
33	АВЛАГА	-	20,269,104.00
335	Бусад авлага	-	20,269,104.00
3351	Байгууллагаас авах авлага	-	20,269,104.00
35	БАРАА МАТЕРИАЛ	76,298,505.76	119,565,623.76
354	Хангамжийн материал	76,298,505.76	119,565,623.76
35410	Бичиг хэргийн материал	1,478,884.00	1,628,504.00
35420	Аж ахуйн материал	2,336,880.00	4,447,130.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	610,000.00
35470	Бусад хангамжийн материал	72,482,741.76	112,879,989.76
36	НӨӨЦИЙН БАРАА	9,265,100.00	656,000.00
36300	Тэжээлийн нөөц	9,265,100.00	656,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,583,478,946.34</u>	<u>1,858,003,017.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,583,478,946.34	1,858,003,017.94
392	Биет хөрөнгө	1,489,844,946.34	1,762,866,601.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,647,199.00	618,647,199.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,389,547.68)	(61,976,172.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	216,360,870.00	267,158,370.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(162,812,726.48)	(178,122,622.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,147,675.53	170,917,330.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(106,495,080.36)	(108,573,689.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,411,887.78	35,865,099.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,463,674.44)	(19,309,351.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,078,030,342.53	1,345,915,994.53
39215	Хуримтлагдсан элэгдэл	(255,426,459.54)	(308,490,017.35)
39217	Ном	834,460.00	834,460.00
393	Биет бус хөрөнгө	93,634,000.00	95,136,416.72
39301	Програм хангамж	-	1,802,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(300,483.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	94,484,000.00	94,484,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(850,000.00)	(850,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,669,042,552.10</u>	<u>1,998,493,745.70</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,669,042,552.10</u>	<u>1,998,493,745.70</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,669,042,552.10	1,998,493,745.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	528,431,611.57	528,431,611.57
512	Хуримтлагдсан үр дүн	915,602,737.77	1,245,053,931.37
51210	Өмнөх үеийн үр дүн	915,602,737.77	915,602,737.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	329,451,193.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	225,008,202.76	225,008,202.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,669,042,552.10</u>	<u>1,998,493,745.70</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	689,128,738.00	929,056,106.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	176,569,051.00	415,340,280.04
120	Нийтлэг татварын бус орлого	176,569,051.00	415,340,280.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	176,569,051.00	415,340,280.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	480,000.00	480,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	176,089,051.00	414,860,280.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,559,687.00	513,715,826.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,512,987.00	73,437,745.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,168,151.00	24,674,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,344,836.00	48,763,745.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	395,046,700.00	440,278,081.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	395,046,700.00	440,278,081.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	591,839,088.04	619,245,223.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	591,839,088.04	619,245,223.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	584,956,389.02	596,138,779.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,856,784.93	265,208,836.51
210101	Үндсэн цалин	233,856,784.93	225,280,543.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,353,316.60
210104	Урамшуулал	-	13,635,873.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	11,939,103.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,733,001.52	31,889,296.67
210201	Тэтгэврийн даатгал	19,217,992.12	20,330,796.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,890,320.00	2,936,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,907,547.00	2,298,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	460,769.00	575,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,256,373.40	5,747,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,224,000.00	61,591,084.00
210301	Гэрэл, цахилгаан	5,286,100.00	3,286,100.00
210302	Түлш, халаалт	56,905,200.00	56,405,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,032,700.00	1,899,784.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,736,833.00	35,446,063.00
210401	Бичиг хэрэг	5,133,400.00	4,164,680.00
210402	Тээвэр, шатахуун	19,232,590.00	21,114,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,059,235.00	3,023,163.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,151,608.00	6,928,200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	35,600.00
2105	Нормативт зардал	92,850.00	1,078,300.00
210502	Хоол, хүнс	-	1,078,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	92,850.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,364,530.00	16,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	16,500.00
210604	Урсгал засвар	3,364,530.00	-
2107	Томилот, зочны зардал	3,943,900.00	1,767,600.00
210702	Дотоод албан томилот	3,943,900.00	1,767,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,580,259.00	51,420,161.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,039,295.00	50,014,247.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	228,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	560,900.00	495,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	525,586.00	364,518.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	178,478.00	273,400.00
210807	Газрын төлбөр	60,000.00	44,196.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,424,230.57	147,720,938.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,222,400.00	41,961,151.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,849,500.00	282,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,352,330.57	105,477,287.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,882,699.02	23,106,443.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	550,000.00	1,830,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	1,830,000.00

Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,332,699.02	1,007,339.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,332,699.02	1,007,339.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	20,269,104.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	20,269,104.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	97,289,649.96	329,779,503.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	328,309.59
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	328,309.59
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(328,309.59)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	97,289,649.96	329,451,196.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	513,039,687.00	514,195,826.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	480,000.00	480,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	480,000.00	480,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	480,000.00	480,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	480,000.00	480,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,559,687.00	513,715,826.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,512,987.00	73,437,745.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,168,151.00	24,674,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,344,836.00	48,763,745.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	395,046,700.00	440,278,081.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	395,046,700.00	440,278,081.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	503,988,687.00	500,914,226.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	503,988,687.00	500,914,226.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	496,855,987.98	477,837,782.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,012,577.27	265,208,836.51
210101	Үндсэн цалин	219,492,577.27	225,280,543.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,353,316.60
210104	Урамшуулал	-	13,635,873.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,520,000.00	11,939,103.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,868,209.71	31,889,296.67
210201	Тэтгэврийн даатгал	19,812,035.71	20,393,796.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,891,370.00	2,873,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,184,334.00	2,298,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	452,933.00	575,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,527,537.00	5,747,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,224,000.00	61,591,084.00
210301	Гэрэл, цахилгаан	5,286,100.00	3,286,100.00
210302	Түлш, халаалт	56,905,200.00	56,405,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,032,700.00	1,899,784.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,059,645.00	27,384,260.00
210401	Бичиг хэрэг	3,400,800.00	3,450,800.00
210402	Тээвэр, шатахуун	18,623,030.00	19,520,097.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,577,915.00	2,853,163.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	297,900.00	1,380,200.00
2105	Нормативт зардал	702,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	702,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,961,330.00	3,592,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	235,000.00	16,500.00
210602	Тавилга	-	620,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	454,300.00
210604	Урсгал засвар	3,726,330.00	2,501,150.00
2107	Томилолт, зочны зардал	3,943,900.00	1,767,600.00
210702	Дотоод албан томилолт	3,943,900.00	1,767,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	132,684,826.00	52,797,561.00

Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	131,144,340.00	51,181,647.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	228,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	667,741.00	705,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	418,745.00	414,518.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	178,000.00	223,400.00
210807	Газрын төлбөр	60,000.00	44,196.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,399,500.00	33,606,994.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,550,000.00	32,876,494.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,849,500.00	730,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,132,699.02	23,076,443.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	1,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,332,699.02	1,007,339.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,332,699.02	1,007,339.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	20,269,104.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		20,269,104.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,051,000.00</u>	<u>13,281,600.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,051,000.00	13,281,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,051,000.00	13,281,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,051,000.00	13,281,600.00
223001	Бусад хөрөнгө	9,051,000.00	13,281,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,051,000.00)</u>	<u>(13,281,600.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	818,313,087.81	1,571,752,902.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	818,313,087.81	1,571,752,902.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	97,289,649.96	97,289,649.96
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	915,602,737.77	1,669,042,552.10
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	915,602,737.77	1,669,042,552.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	915,602,737.77	1,669,042,552.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	309,482,572.88	309,482,572.88
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,431,611.57	225,008,202.76	1,225,085,310.65	1,978,525,124.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	477,777,300.00	439,750,741.18	38,026,558.82	92%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	477,777,300.00	439,750,741.18	38,026,558.82	92%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,977,300.00	437,950,741.18	38,026,558.82	92%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291,505,000.00	264,263,836.51	27,241,163.49	91%
210101	Үндсэн цалин	241,740,400.00	225,280,543.91	16,459,856.09	93%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,384,000.00	14,353,316.60	7,030,683.40	67%
210104	Урамшуулал	16,860,600.00	13,635,873.00	3,224,727.00	81%
210105	Гэрээт ажлын хөлс	11,520,000.00	10,994,103.00	525,897.00	95%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,373,000.00	31,889,296.67	7,483,703.33	81%
210201	Тэтгэврийн даатгал	27,632,700.00	20,393,796.67	7,238,903.33	74%
210202	Тэтгэмжийн даатгал	2,912,100.00	2,873,900.00	38,200.00	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,371,100.00	2,298,900.00	72,200.00	97%
210204	Ажилгүйдлийн даатгал	587,000.00	575,000.00	12,000.00	98%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,870,100.00	5,747,700.00	122,400.00	98%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,239,500.00	61,591,084.00	1,648,416.00	97%
210301	Гэрэл, цахилгаан	3,286,100.00	3,286,100.00	-	100%
210302	Түлш, халаалт	56,920,700.00	56,405,200.00	515,500.00	99%
210303	Цэвэр, бохир ус	3,032,700.00	1,899,784.00	1,132,916.00	63%
2104	Хангамж, бараа материалын зардал	28,606,600.00	27,804,060.00	802,540.00	97%
210401	Бичиг хэрэг	3,450,800.00	3,450,800.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	19,520,100.00	19,520,097.00	3.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,655,700.00	2,853,163.00	802,537.00	78%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,800,000.00	-	100%
2105	Нормативт зардал	399,000.00	-	399,000.00	0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	399,000.00	-	399,000.00	0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,580,000.00	12,355,450.00	224,550.00	98%
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00	-	100%
210602	Тавилга	1,000,000.00	1,000,000.00	-	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	1,854,300.00	145,700.00	93%
210604	Урсгал засвар	2,580,000.00	2,501,150.00	78,850.00	97%
2107	Томилолт, зочны зардал	1,878,600.00	1,767,600.00	111,000.00	94%
210702	Дотоод албан томилолт	1,878,600.00	1,767,600.00	111,000.00	94%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,395,600.00	31,300,414.00	95,186.00	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,706,000.00	29,684,500.00	21,500.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	228,000.00	228,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	706,000.00	705,800.00	200.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	457,600.00	414,518.00	43,082.00	91%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	238,000.00	223,400.00	14,600.00	94%
210807	Газрын төлбөр	60,000.00	44,196.00	15,804.00	74%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	6,979,000.00	21,000.00	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,979,000.00	21,000.00	99%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,800,000.00	1,800,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,800,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,800,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	477,777,300.00	440,758,081.00	37,019,219.00	92%

Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	476,777,300.00	440,278,081.00	36,499,219.00	92%
132001	Орон нутгийн төсвөөс	476,777,300.00	440,278,081.00	36,499,219.00	92%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	480,000.00	520,000.00	48%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	480,000.00	520,000.00	48%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00	-	100%
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100%
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00	-	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	53,168,641.00	(53,168,641.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	53,168,641.00	(53,168,641.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	53,168,641.00	(53,168,641.00)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	945,000.00	(945,000.00)
210105	Гэрээт ажлын хөлс	-	945,000.00	(945,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	24,347,147.00	(24,347,147.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	24,347,147.00	(24,347,147.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	27,876,494.00	(27,876,494.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	27,876,494.00	(27,876,494.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	73,437,745.00	(73,437,745.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	24,674,000.00	(24,674,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	48,763,745.00	(48,763,745.00)

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээн Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Г.Алтанцацрал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03/81 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газар нь 2020 оныг “Хөрөнгө оруулалтыг дэмжих жил” болгон тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 276,893.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,768.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд суур үзүүлэлтийг өөрчлөх шаардлагагүй гэж үзэж гүйцэтгэлийн үе шатны нийт зардлын 619,573.5 мянган төгрөгийн 2 хувиар тооцож 12,391.5 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 274,524.1 мянган төгрөгөөр буюу 17.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		20,269.10	20,269.10
Урьдчилгаа			0.00
Бараа материал	76,298.50	119,565.60	43,267.10
Үндсэн хөрөнгө	1,583,478.90	1,858,003.00	274,524.10
Нийт хөрөнгө	1,669,042.60	1,998,493.70	329,451.10
Өр төлбөр			0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,669,042.60	1,998,493.70	329,451.10
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,669,042.60	1,998,493.70	329,451.10

Авлага дансны үлдэгдэл 20,269.1 мянган төгрөг болж 20,269.1 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 119,565.6 мянган төгрөг болж 43,267.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан бараа материал бүртгэлд тусгаснаар өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,858,003.0 мянган төгрөг болж 274,524.1 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,998,493.7 мянган төгрөг болж 329,451.1 мянган төгрөгөөр өссөн байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 239,927.4 мянган төгрөгөөр буюу 34.8 хувиар өссөн байна. Өмнөх оноос үнэ төлбөргүй орлогын дүн өссөн үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 7,437.5 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал өсөж, бараа үйлчилгээний бусад зардал буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 482,385.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 482,385.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 14,608.3 мянган төгрөгөөр бууруулж 467,777.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 477,777.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 476,777.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгохоор, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 440,278.3 мянган төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлогоос 480.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, орон нутгийн төсөвт 1,007.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 460,701.3 мянган төгрөг буюу 96 хувьтай байна. Энэ нь орон нутгийн төсвөөс санхүүжилт дутуу олгосон, туслах үйл ажиллагааны орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоор 1,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 480.0 мянган төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг 48 хувиар биелүүлж, 52 хувиар тасарсан байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	480.0	520.0	48
Нийт дүн	1,000.0	480.0	520.0	48

Туслах үйл ажиллагааны орлогыг байрны түрээсийн орлогоор бүрдүүлдэг ба тайлант онд түрээсийн байранд эвдрэл гарч түрээслэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 24,674.0 мянган төгрөг, аймгийн СХ-ээс 4,892.5 мянган төгрөг, аймгийн ХХАГ-аас 10,640.0 мянган төгрөг, аймгийн БОАЖГ-аас 10,360.0 мянган төгрөг, ГХБХБГ-аас 247.9 мянган төгрөг, ГБХЗХГ-аас 500.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 22,123.3 мянган төгрөгийг төвлөрүүлэн холбогдох зардалд зарцуулсан байна.

Үүнээс ХАОСТ болон бусад тооллогын ажилд 3,700.6 мянган төгрөг, Үлийн цагаан оготно устгалын зардал 10,640.0 мянган төгрөг, Хөрөнгө оруулалтаар 22,784.0 мянган төгрөг, ОН-ийн цагдаагийн урамшуулалд 1,890.0 мянган төгрөг, Булаг шандын эхийг хамгаалах ажилд 4,802.0 мянган төгрөг, өвс тэжээл татахаар 9,352.0 мянган төгрөг нийт 53,168.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 20269,1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 53 мэдээллээс хугацаандаа оруулсан 46 мэдээлэл, 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	180.3					
Албан шаардлага							
Зөвлөмж	1	300.0					
Нийт дүн	2	480.3					

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18,413.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,287.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,125.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, зөрчлийг арилгах, таслан зогсоох 3 зөвлөмж хүргүүлжээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант оны цалингийн бүртгэлийг үзэхэд урьдчилгаа цалинг авлагаар бүртгэх байтал өглөгөөр бүртгэж нийт 8,820.0 мянган төгрөгийг буруу бүртгэж тайлагнасан байна. Үүнийг аудитын явцад залруулав.

2. Төлөвлөлтийн үе шатанд ирүүлсэн эхний хагас жилийн тайлангийн орлого үр дүнгийн тайланд бараа материал акталсны зардалд 2,467.8 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан нь жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдаагүй байна. Энэ нь тус байгууллагын хагас санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн нь жилийн эцсийн тайланд залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7,125.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7,125.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, зөрчлийг арилгах, таслан зогсоох 3 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд нийт 7,125.6 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна. Энэ нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 670,7 мянган төгрөгийн цалин олгосон, түлш халаалтын зардлаас 5,000.0 мянган төгрөгийг засварын ажлын хөлс төлөхөд, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1,244.9 мянган төгрөгийн эд худалдан авахад, даатгалын үйлчилгээний төлбөрийн зардлаас 210.0 мянган төгрөгөөр нотариатын дардасны үнийг шилжүүлэн зарцуулсан байна. Энэ нь үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа ба мөн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоох.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудалд байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой:

- 1.1. Илрүүлэлт Тайлант оны үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүртгэлийг үзэхэд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд ашиглаж байна. Энэ нь эрх ба үүрэг батламж, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Эрсдэл: Үндсэн хөрөнгө ашиглалт, хадгалалт хамгаалалтгүй болох.
- 1.3. Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 7.1-д "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, ... эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж, шийдвэрлүүлнэ" гэж заасныг дагуу ашиглах хугацаа дууссан хөрөнгийн үнэ, ашиглах хугацааг тогтоох, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах асуудлыг холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлж, ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байхгүй

2. Балансын данстай холбоотой асуудал

- 2.1 Илрүүлэлт: Тайлант онд хагас жилийн болон жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийх тухай тушаал байхгүй байна. Мөн тооллогын баримт гэсэн нэртэй архивын баримтыг үзэхэд тооллого хийсэн гэх баримт материал хангалтгүй, тооллогын комиссын илтгэх хуудас байхгүй байна. Энэ нь 2020 онд тус байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгөнд тооллого хийсэн эсэхийг бүрэн нотлох боломжгүй байна. Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт алдагдах, үрэгдэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.
- 2.3 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-т заасны дагуу тооллогын комиссын үүргийг бүрэн хэрэгжүүлэх, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны маягтаар холбогдох тооцоог гаргаж ажиллах.
- 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байхгүй

3. Орлогын данстай холбоотой

- 3.1 Илрүүлэлт: Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоор 1,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 480.0 мянган төгрөгийн төвлөрүүлж, 520.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Төлөвлөсөн орлого 52 хувиар тасарсан байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа ба Төсвийн тухай хуулийн 6.2.2-т жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Эрсдэл: Орлогын төлөвлөгөө тасарч төлөвлөсөн зардал хүрэлцэхгүй байх.

3.3 Өгсөн зөвлөмж: Тайлант онд төлөвлөсөн орлогыг бүрэн бүрдүүлж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			ДГА-2021/106/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ</i>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант оны цалингийн бүртгэлийг үзэхэд урьдчилгаа цалинг авлагаар бүртгэх байтал өглөгөөр бүртгэж нийт 8,820.0 мянган төгрөгийг буруу бүртгэж тайлагнасан байна. Үүнийг аудитын явцад залруулав.	8,820.0	Аудитын явцад залруулав	ЗДТГ-ын дарга	Г.Алтанцацрал
2	Төлөвлөлтийн үе шатанд ирүүлсэн эхний хагас жилийн тайлангийн орлого үр дүнгийн тайланд бараа материал акталсны зардалд 2,467.8 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан нь жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдаагүй байна. Энэ нь тус байгууллагын хагас санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн нь жилийн эцсийн тайланд залруулав.	2,467.8	Аудитын явцад залруулав	ЗДТГ-ын дарга	Г.Алтанцацрал
3	Тайлант оны үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүртгэлийг үзэхэд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд ашиглаж байна.	-	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга	Г.Алтанцацрал
4	Тайлант онд хагас жилийн болон жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийх тухай тушаал байхгүй байна. Мөн тооллогын баримт гэсэн нэртэй архивын баримтыг үзэхэд тооллого хийсэн гэх баримт материал хангалтгүй, тооллогын комиссын илтгэх хуудас байхгүй байна. Энэ нь 2020 онд тус байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгөнд тооллого хийсэн эсэхийг бүрэн нотлох боломжгүй байна.	-	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга	Г.Алтанцацрал
5	Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоор 1,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 480.0 мянган төгрөгийн төвлөрүүлж, 520.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Төлөвлөсөн орлого 52 хувиар тасарсан байна.	-	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга	Г.Алтанцацрал

6	Тайлант онд нийт 7,125.6 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна. Энэ нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 670,7 мянган төгрөгийн цалин олгосон, түлш халаалтын зардлаас 5,000.0 мянган төгрөгийг засварын ажлын хөлс төлөхөд, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1,244.9 мянган төгрөгийн эд худалдан авахад, даатгалын үйлчилгээний төлбөрийн зардлаас 210.0 мянган төгрөгөөр нотариатын дардасны үнийг шилжүүлэн зарцуулсан байна	7,125.6	Албан шаардлага тогтоох	ЗДТГ-ын дарга	Г.Алтанцацрал
ДҮН		18,413.4			